

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ**

2024 оны 06 сарын 26

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж, хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Оноо
Үүрэг, даалгавар НЭГ: Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах салбар хороодын ажлын уялдаа холбоог сайтар хангаж, бэлтгэл ажлын явцын талаар 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр хэвлэл, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулах.				
1	Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар нь “Үндэсний их баяр наадам”-ын хүрээнд дүүрэг дээр зохион байгуулагдах арга хэмжээний талаар хэвлэл, олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	Дээд газраас удирдамж чиглэл ирээгүй.		30
Үүрэг, даалгавар ЗУРГАА: Нийслэлийн хэмжээнд Гэрэлтүүлгийн асалтыг нэмэгдүүлж, гэрлийн шонг будаж, засварлах ажлыг зохион байгуулах.				
2	Нийслэл Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас дүүрэгт шилжин ирсэн чиг үүрэг болох гэрэлтүүлгийн үйлчилгээнд 2024 оны 05 сарын 17-ны өдрөөс хяналт тавихад 64 гэрэлтүүлэг асахгүй байсныг хариуцагч “Соёндрийм” ХХК-д мэдэгдэж засварласан. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас ирүүлсэн 2024 оны 01/1185 тоот албан бичгийн хэрэгжилтийг хангаж 2024 оны 06 дугаар сарын 10-наас 11-нд шилжих шөнө дүүргийн 1-24 дүгээр хороодын нутаг дэвсгэрт хороо тус бүрээр гэрэлтүүлгийн асалтад хяналт, шалгалт хийж нотлох баримтыг илтгэх хуудас, зургаар авч ажилласан байна. Хяналт, шалгалтаар илэрсэн асахгүй байгаа 204 гэрэлтүүлгийг 2024 оны 06 дугаар сарын гүйцэтгэлээс хасаж тооцох, асахгүй байгаа гэрэлтүүлгийг засварлаж, илтгэх хуудсыг, нотлох баримтын хамт ирүүлэх тухай хугацаатай үүрэг даалгаврыг хүргүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.			100
Үүрэг, даалгавар ДОЛОО: Хог, хаягдлыг цагийн хуваарийн дагуу ачиж, тээвэрлэх зохицуулалтыг жигдрүүлэх ажлыг газар дээр нь явж хэрэгжилтэд хяналт тавих.				

3	Дүүргийн 1-24 дугаар хороо буюу 1, 2, 3 дугаар бүсийн айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын хог хаягдлыг цуглуулж тээвэрлэхэд “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-иуд нийт 45 машин, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр ханган тогтмол ачиж тээвэрлэн ажиллаж байна. - 1 дүгээр бүс болох төвийн бүсийн хог тээвэрлэлтийг хуваарийн дагуу өдөр бүр тээвэрлэдэг; - 2, 3 дугаар бүс буюу гэр хороолол, зуслангийн бүсийн хог хаягдлыг сард 3-4 удаагийн давтамжтай тээвэрлэн ажиллаж байгаа ба зуны улиралд зуслан ногоон бүсийн хог хаягдлын тээвэрлэлтийн давтамжийг нэмэгдүүлэн сард 5-6 удаагийн давтамжтай тээвэрлэдэг; - Зуслангийн бүсийн нэгдсэн хогийн цэгүүдийг өдөрт 3-4 удаагийн давтамжтай тээвэрлэн ажиллаж байна. “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК нь хог тээвэрлэлтийг шөнийн цагийн хуваарьт шилжүүлэн төвийн бүсийн 6 хорооны нийт 103 байршлын аж ахуйн нэгж, байгууллага, орон сууцны хорооллын хог хаягдлыг оройны 20:00 цагаас өглөөний 05:00 цагийн хооронд тээвэрлэн нэмэлт хуваарь гарган ажиллаж байна. Тээвэрлэлтийн явцад хяналт шалгалтаар ил задгай хог хаягдал үүссэн, эзэнгүй барилгын хог хаягдлыг булан тохойд хаясан, хуваарийн бус цагаар айл өрх аж ахуй нэгж, байгууллагууд ил задгай хаясан гэх зөрчлүүд маш ихээр илэрдэг тул цаг тухайд нь арга хэмжээ авч ажилласан.			100
Үнэлгээний дундаж				76.6%